



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/305
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол-Солонгосын Политехник коллежийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол-Солонгосын Политехник коллежийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Аудитаар Нийгмийн даатгал болон хүн амын орлогын албан татварын 138,4 сая төгрөгийн өр, төлбөрийг холбогдох газартай нь тооцоо нийлж баталгаажуулаагүй, батлагдсан төсвийг 24,3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь батлагдсан төсвөөс гадуур хөрөнгө зарцуулсан, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн ажилчдын цалинд шаардлагатай байгаа 10,7 сая төгрөгийг түр олгох тухай төвийн даргын 2016 оны 01/09 дугаартай хүсэлтийг үндэслэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Хягаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Монгол-Солонгосын Политехник коллежийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Аудитор: Ц.Сугармаа

Утас: 99151254

Цахим хаяг: sugarmaa23@gmail.com

Компанийн хаяг: “И Эс Эс Эс Аудит” ХХК

Байршил: СБД, 1-р хороо Жамьяан гүний
гудамж-5, Ар Монгол Травэлийн байр

Цахим хаяг: esss.audit@gmail.com

2017 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

- 1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**
- 2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**
- 3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**
- 4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**
- 5. Дотоод хяналт**
- 6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**
- 7. Шилэн дансны мэдээлэл**
- 8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**
- 9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**
- 10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**
- 11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**
- 12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**
- 13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**
- 14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**
- 15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**
- 16. Зөвлөмж**
- 17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт**

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд МСПК-ийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/51/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

МСПК-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт юм.

МСПК-ийн удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МСПК-ийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөж, тус компанийн ахлах аудитор Д.Лхагвасүрэн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/, /ТАБ-СТА-А-10/

МСПК-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд тус компанид ирүүлсэн.

Тус компанийн аудитын баг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-ны дотор УАГ-ын холбогдох албан тушаалтнуудаар хянуулсны дараагаар дүгнэлтийг албан ёсоор болгож, МСПК-ийн удирдлагад гардуулна.

ХОЁР. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

МСПК-ийн удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн албаны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд

мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

ГУРАВ. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол-Солонгосын политехник коллежийн үндсэн зорилт нь иргэний сонирхол, авьяас чадварыг харгалзан, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох, ур чадварыг нь дээшлүүлэх замаар хүн амд үзүүлэх боловсролын түвшин, мэргэжлийн сургалтын хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна. ТАБ-СТА-A-1 маягтад тодорхой тусгасан.

Боловсролын байгууллагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай .Төсвийн тухай хууль, Боловсролын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Мэргэжлийн боловсролын тухай, Авилгатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон Коллежийн дүрэм, байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм, шалгалтын улирлын журмуудыг мөрдөж ажиллаж байна.

Улаанбаатар хотод загвар Политехник коллеж байгуулах төслийн хүрээнд БНСУ-ын засгийн газраас Монгол улсын засгийн газарт үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр хэрэгжих “Монгол-Солонгосын Политехник коллежийн чадавхийг бэхжүүлэх” төслийн хэлэлцээрийг 2010 оны 08-р сард үзэглэжээ. Үүний гол зорилго нь:

- БНСУ-ын Техникийн болон Мэргэжлийн боловсрол, сургалтын технологи, туршлагаас хуваалцан улмаар багш, удирдах ажилтны чадавхийг нэмэгдүүлэх
- Улаанбаатар хотод “Загвар Политехник коллеж”-ийг байгуулснаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын загвар орчин бүрдүүлэх
- Монголын хөдөлмөрийн зах зээлд чадварлаг мэргэжилтэн бэлтгэн гаргах
- Практик сургалт болон үйлдвэрийн дадлагын уялдаа холбоог нэмэгдүүлэх явдал юм.

2013 онд БНСУ-д барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендэр явагдаж, “Хан Суль” ХХК шалгарснаар 2014 оны 04-р сараас эхлэн барилгын ажлыг эхэлж 2016 онд батлагдсан зураг төслийн дагуу 3 давхар бүхий 1 блок- 2 давхар бүхий 1 блок - 350 хүний суудалтай соёл урлагын заал, нийт 4266 метр.кв барилгын ажлыг 100 хувь гүйцэтгэж ашиглалтанд оруулжээ.

Мөн төслийн хүрээнд 2.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг хамгийн сүүлийн үеийн шинэ загвараар өргөтгөлийн барилгыг тоноглож суурилуулсан байна.

2016-2017 оны хичээлийн жилд 29 мэргэжлийн чиглэлээр элсэлт зохион байгуулж, мэргэжлийн боловсрол олгох сургалтанд 362, техникийн боловсрол олгох сургалтанд 182, захиалгат болон насанд хүрэгчдийн сургалтанд 69 суралцагчдыг тус тус элсүүлж, нийт 614 суралцагчидтай үйл ажиллагааг явуулж байна. Орон нутгаас суралцахаар ирсэн суралцагчид оюутны дотуур байраар хангаж ажиллаж байна. Тус коллеж нь гадаадын болон дотоодын төслийн хөрөнгө оруулалтаар сургалтын материаллаг бааз суурийг орчин үеийн шинэ шийдэл бүхий тоног төхөөрөмжөөр тоноглогсон, сургалтын оновчтой менежментээр зохион байгуулж, сургалтын орчин нөхцөлийг хангалттай түвшинд бүрдүүлсэн байна.

Тус коллежийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

ДӨРӨВ. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар МСПК-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг данс бүрээр түүвэрлэн гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад МСПК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох ХХК-иас гаргасан ACOLOUS програмыг ашиглаж, санхүүгийн тайланг гаргаж байна. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/218 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу санхүү, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

МСПК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ гарсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг түвшинг тооцохдоо төлөвлөлтийн шатанд төслийн нийт хөрөнгийн дүнгээс 1 хувиар буюу 111.1 сая төгрөгөөр урьдчилан тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд Нийгмийн даатгал болон хүн амын орлогын албан татварын 138.4 сая төгрөгийн өр, төлбөрийг холбогдох газартай нь тооцоо нийлж баталгаажуулаагүй,

батлагдсан төсвийг 24,3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь батлагдсан төсвөөс гадуур хөрөнгө зарцуулсан, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн ажилчдын цалинд шаардлагатай байгаа 10.7 сая төгрөгийг зориулалт бусаар олгосон зэрэг алдаа, зөрчлүүд нь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшинг 51.6 сая төгрөгөөр хэтрүүлэхэд хүргэж, гүйцэтгэлийн шатанд энэ хэмжээгээр өөрчлөхөөр тооцов.

Холбогдох дээд байгууллага, Мэргэжлийн хяналтын газар болон ҮАГ-аас өмнөх онд хийсэн санхүүгийн тайлангаар илрүүлсэн зөрчил дутагдал, ихээхэн хэмжээний төлбөрийн акт, албан шаадлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна гэж үзэн АОУС 320-ын шаардлагын дагуу үнэ цэнийн хувьд материаллаг бус ч, шинж чанарын хувьд материаллаг эрсдэл гэж төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг ач холбогдлоор үнэлж өөрчлөн дахин тооцов.

ТАВ. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуульд хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд тайлант жилд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хичээл сургалтын орчин, дадлагын газар анги танхим дахь үйл ажиллагаа, доттуур байр, цайны газрын үйл ажиллагаа, сургуулийн өмч хөрөнгө, хадгалалт хамгаалалтын байдалд шалгалт хийсэн байна.

Дотоод хяналтын ажилтан ажиллаж, шалгалт хийж байгаа боловч тус сургуулийн санхүү, үйл ажиллагаанд өмнө нь ажиллаж байсан удирдлагын хяналт сул байсан, мөн нягтлан бодогч, эд хариуцагчаар ажиллаж байсан ажилтнуудын хариуцлагагүй байдал нь Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын газраас тайлант жилд хийсэн дараах шалгалтуудаар гарсан алдаа, зөрчлөөс харагдаж байна.

Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийг орлогод аваагүй, бараа материал, сургалтын зардлын үндсэн баримт байхгүй
- 2015 онд багш, ажиллагсдад 279,9 сая төгрөг, 2016 онд 197,3 сая төгрөгийн цалин илүү олгосон
- Захирлаар ажиллаж байсан Ц.Эрдэнэбаатар 135 тоот тушаалаар сарын үндсэн цалингаа 1,2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож илүү авсан
- Тус коллежийн өмнө ажиллаж байсан нягтлан бодогч 14 удаагийн үйлдлээр мөнгө карт руу шилжүүлж төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан

- Тус коллежийн захирлаар ажиллаж байсан Г.Оюунбилэг 200,0 мянган төгрөг зориулалт бус зарцуулсан
- Тус коллежийн захирлаар ажиллаж байсан Г.Оюунбилэг буруу шийдвэр гаргасны улмаас 8.9 сая төгрөгийн зөрчил гаргасан.
- Тус коллежийн кассын нярав С.Дэжидмаа 2016 оны эхний 3 улирлын кассын тайланд 231,0 мянган төгрөгийн бараа материал орлогод авч зарцуулаагүй
- Тус коллежийн захирлаар ажиллаж байсан Г.Оюунбилэгт холбогдох шүүхийн материал нотариатаар батлуулсны зардалд кассаас мөнгө зарцуулсан
- Тус коллежийн захирлаар ажиллаж байсан Ц.Эрдэнэбаатарын 840,0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү авсан зэрэг алдаа зөрчил илэрсэн нь дотоод хяналтын систем хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Аудитаар дотоод хяналттай холбоотой зөвлөмж өгөх болно. Тус сургуулийн захирал Б.Эрдэнэбат 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдөр, нягтлан бодогч Ц.Жавзандулам нар шинээр томилогдож ирсэн бөгөөд аудитын хугацаанд зарим нэг нягтлан бодогч, эд хариуцагчдыг халж сольсон асуудлууд аудитын үйл ажиллагаанд нэлээд хүндрэл учрууллаа.

ЗУРГАА. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Тус коллеж тайлант жилд улсын төсвөөс 2320.0 сая төгрөг урсгал зардалд батлагдаж, гүйцэтгэлээр 2344.3 сая төгрөгийг авч, төсвийг 24.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэхүү төсөв хэтрүүлсэн шалтгаан нь батлагдсан төсвөөс гадуур хөрөнгө зарцуулсан, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн ажилчдын цалинд шаардлагатай байгаа 10.7 сая төгрөгийг түр олгох тухай төвийн даргын 2016 оны 01/09 дугаартай хүсэлтийг үндэслэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

ДОЛОО. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2016 оны нийт зээлийн хөрөнгөөр баталсан төсөв болон гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар вэбсайт хуудсанд байршуулсан бөгөөд тайлант жилийн байдлаар зарим мэдээ, мэдээллийг хагас дутуу оруулсан байна. Энэ талаар цаашид анхаарч ажиллах талаар сургуулийн удирдлага, ахлах нягтлан бодогч болон хяналт шинжилгээ хариуцсан ажилтнуудад аудитын явцад зөвлөгөө өгсөн болно.

НАЙМ. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын данс бүрээр эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд орлого, зарлагын дансны зүйл ангиар задалвал нийт 9 нарийвчилсан горим, сорил хийж дүгнэв.

Мэргэжлийн хяналтын газрын албан шаардлага Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас хийсэн шалгалтаар гарсан зөрчил дутагдал, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн материаллаг бус алдаа, зөрчлүүд дотоод хяналтыг сулруулж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй, зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүргэж болзошгүй юм.

ЕС. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

МСПК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материалын зардал, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, цалин урамшуулал, сургалт семинар болон үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 60 хувь, мөнгөн хөрөнгийн 60 хувь, нийт зардлын 50-60 хувийг тус тус түүвэрчилсэн сорил хэрэгжүүлсэн болно.

БНСУ-ын засгийн газраас Монгол улсын засгийн газарт үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд 3 блок хичээлийн байр 5.0 тэрбум төгрөг, 2.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж болон хичээл практикийн материалуудыг хандиваар авч хөрөнгөнд бүртгэж авчээ.

АРАВ. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах материаллаг бус алдаа илэрлээ. /ТАБ-СТА-В-4/ Үүнд:

1. БНСУ-ын ОУХАБ-ын санхүүжилтээр ирсэн эргэлтийн хөрөнгө, бараа материалыг багш нар хариуцаж байгаа нь Санхүү, Эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот “Маягт, заавар батлах тухай” тушаалын 2, 3, 5, 6, 7, 8, 9 дүгээр заалтуудыг зөрчиж бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэхүү тушаалын дагуу тус коллежийн эд хариуцагч нь эргэлтийн хөрөнгө, бараа материалыг нэг бүрчлэн хүлээн авч, сар бүр бараа материалын тайланг гаргаж байх

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн даргын 2016 оны 01/09 дугаартай доорх хүсэлтийг тавьжээ. Тус коллежийн захирал асан Г.Оюунбилэгт 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний

өдрийг хүртэлх ажилчдын цалинг тус сургуулийн дансаар авлага үүсгэн олгоод төрийн сангийн данс нээгдэхээр буцаагаад өгөх...Гэтэл цалингийн зардлаас 10.7 сая төгрөг олгож Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41 дүгээр зүйлийг зөрчиж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн нь: Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвөөс 10.7 сая төгрөгийг нөхөн төлүүлж сургуулийг хохиролгүй болгох арга хэмжээ авах

3. Тус коллежид суралцагсдын сургалтын төлбөрийг мөнгөн сууриар бүртгэж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх **...Байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө** гэсэн заалтыг зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг үндэслэн сургалтын төлбөрийг аккрузл сууриар хөтөлж байх

4. Тайлант жилд тус коллежийн санхүү, үйл ажиллагаанд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас шалгалт хийж, цалин илүү олгосон, хөрөнгө мөнгө завшсан зэрэг 10 зүйлээр төлбөрийн акт, албан шаардлага өгсөн бөгөөд алдаа, зөрчлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус алдаа зөрчлийг илрүүлж өгсөн 9 зөвлөмжийн хэрэгжилт 65.0 хувьтай байгаагаас харахад дотоод хяналт хангалтгүй ажилласан гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын ажилтны мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, дотоод аудитын дүрэм, журмыг боловсруулж мөрдөж ажиллах

5. Тайлант жилд шинээр элсэн суралцагчдаас үйлдвэр сургалтын зардалд зориулан нийт 54.0 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.9 дэх, 4.3 дахь заалтыг тус тус зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: Санхүү, үйл ажиллагаандаа Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, цаашид харьяа яаманд төсвийн нэмэлт орлогын болон зардлын саналаа хүргүүлж, орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр хийж үндэслэлтэй төлөвлөж байх

АРВАН НЭГ. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад санхүүгийн тайланд гарсан зарим хөрөнгийн тооцооллын алдаа, бараа материалын үнэлгээг зөв болгож, санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно.

АРВАН ХОЁР. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Төслөөр ирсэн тоног төхөөрөмж, бараа материалын зарцуулалтын байдалд тавьж байгаа удирдлагын хяналтыг чухалчлан үзэх болно.

АРВАН ГУРАВ. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

МСПК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үзэж, дүгнэх болно.

АРВАН ДӨРӨВ. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус коллежийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар сургалтын төлбөрийн 56.8 сая төгрөг, цалингийн 10.7 сая төгрөг нийт 67.5 сая төгрөгийн тоон дүнтэй алдаа, зөрчил илэрсэн байна.

АРВАН ТАВ. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 9 зөвлөмж өгч, зөвлөмжийг биелүүлэх талаар сургуулийн удирдлага арга хэмжээ авч ажиллаагүй, биелэлт нь 65.0 хувьтай гэж үзэв.

АРВАН ЗУРГАА. Зөвлөмж:

Менежментийн захидалд материаллаг бус алдаа, зөрчлийн талаар бичиж, зөвлөмж өгсөн болно.

АРВАН ДОЛОО. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Батлагдсан төсвийг 24.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, тайлант жилд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар арга хэмжээ аваагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллаагүй байна.

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол МСПК-ийн удирдлагын гаргасан 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон тодруулга, тэмдэглэлийг тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд

нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон бусад холбогдох хавсралт хуудсуудыг тус тус хавсаргав.



МОНГОЛ-СОЛОНГОСЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Зардал.....3

Асуудал 2

Орлого.....4

Асуудал 3

Дотоод хяналт, үнэлгээ.....5

Асуудал 4

Мөнгөн хөрөнгө.....6

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг МСПК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Тус компани энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой өгч байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол Солонгосын Поитехник Коллежийн удирдлага болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

а. БНСУ-ын ОУХАБ-ын санхүүжилтээр ирсэн эргэлтийн хөрөнгө, бараа материалыг багш нар хариуцаж байгаа нь Санхүү, Эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот “Маягт, заавар батлах тухай” тушаалын 2, 3, 5, 6, 7, 8, 9 дүгээр заалтуудыг зөрчиж бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргахгүй байна.

б. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн даргын 2016 оны 01/09 дугаартай цалингийн зардалд түр 10.7 сая төгрөгийг олгох тухай хүсэлтийг тавьжээ. Үүний дагуу 10.7 сая төгрөг олгож Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41 дүгээр зүйлийг зөрчиж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх

ҮАГ-ын зөвлөмж

Энэхүү тушаалын дагуу тус коллежийн эд хариуцагч нь эргэлтийн хөрөнгө, бараа материалыг нэг бүрчлэн хүлээн авч, сар бүр бараа материалын тайланг гаргаж байх

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвөөс 10.7 сая төгрөгийг нөхөн төлүүлж сургуулийг хохиролгүй болгох арга хэмжээ авах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Тус коллежид суралцагсдын сургалтын төлбөрийг мөнгөн сууриар бүртгэж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх **...Байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө** гэсэн заалтыг зөрчиж байна

Эрсдэлүүд

НББ-ийн суурийг буруу бүртгэх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг үндэслэн сургалтын төлбөрийг аккрузл сууриар хөтөлж байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Тайлант жилд тус коллежийн санхүү, үйл ажиллагаанд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас шалгалт хийж, цалин илүү олгосон, хөрөнгө мөнгө завшсан зэрэг 10 зүйл дээр төлбөрийн акт, албан шаардлагыг өмнө ажиллаж байсан захирал, нягтлан бодогч нарт өгсөн боловч алдаа, зөрчлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус алдаа зөрчлийг илрүүлж, өгсөн 9 зөвлөмжийн хэрэгжилт 65.0 хувьтай байгаагаас харахад дотоод хяналт хангалтгүй ажилласан гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналтын систем үнэлэх

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод хяналтын ажилтны мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, дотоод аудитын дүрэм, журмыг боловсруулж мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

Асуудал 4: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №4
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант жилд шинээр элсэн суралцагчдаас үйлдвэр сургалтын орлогыг 51.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 118.0 сая төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөлтийг тооцоо, судалгаан дээр үндэслэж төлөвлөөгүй, мөн батлагдсан төсвөөс гадуур 54.0 сая төгрөгийг бэлнээр зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.9 дэх, 4.3 дахь заалтыг тус тус зөрчиж байна

ҮАГ-ын зөвлөмж

Санхүү, үйл ажиллагаандаа Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, цаашид харьяа яаманд төсвийн нэмэлт орлогын болон зардлын саналаа хүргүүлж, орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр хийж үндэслэлтэй төлөвлөж байх

Эрсдэлүүд

Мөнгөн хөрөнгийн журам зөрчсөн эсэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3	00.00	00.00
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		00.00	00.00
33	АВЛАГА	4	14,618,748.00	14,911,700.00
3305	Бусад авлага		14,618,748.00	14,911,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5	296,218,304.78	729,040,379.50
3501	Түүхий эд материал		140,807,206.18	569,256,322.50
3504	Хангамжийн материал		155,411,098.60	159,784,057.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		310,837,052.78	743,952,079.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6	3,441,838,003.46	10,919,548,027.70
3902	Биет хөрөнгө		3,438,354,669.98	10,916,614,694.18
39020101	Барилга, байгууламж		3,602,748,500.00	8,626,584,158.00
39020102	Хуримтлагдсан элэгдэл		-1,481,213,585.37	-1,548,236,943.22
39020201	Авто тээврийн хэрэгсэл		111,755,000.00	224,836,881.86
39020202	Хуримтлагдсан элэгдэл		-31,593,777.76	-43,566,442.44
39020301	Машин, тоног төхөөрөмж		2,032,330,178.87	4,127,330,189.28
39020302	Хуримтлагдсан элэгдэл		-954,778,894.21	-1,192,138,948.44
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил		280,682,464.22	872,048,900.09
39020402	Хуримтлагдсан элэгдэл		-170,696,750.71	-199,013,052.45
39020501	Зам гүүрийн барилга байгууламж		116,759,000.00	116,759,000.00
39020502	Хуримтлагдсан элэгдэл		-110,637,073.76	-112,579,557.20
39020803	Номын фонд		42,999,608.70	44,590,508.70
39020801	Бусад үндсэн хөрөнгө		1,590,668.28	1,590,668.28
39020802	Хуримтлагдсан элэгдэл		-1,590,668.28	-1,590,668.28
3903	Биет бус хөрөнгө		3,483,333.48	2,933,333.52
39030101	Програм хангамж		11,150,000.00	11,150,000.00
39030102	Хасагдуулга		-7,666,666.52	-8,216,666.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,441,838,003.46	10,919,548,027.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,752,675,056.24	11,663,500,107.20
41	Богино хугацаат өр төлбөр		42,412,178.16	138,488,856.70
4103	Өглөг		42,412,178.16	138,488,856.70
410301	Ажиллагчидтай холбогдсон өглөг		19,914,423.74	128,746,343.20
410302	Бараа үйлчилгээний зардлын өглөг		9,847,754.42	4,648,083.50
410306	Бусад өглөг		12,650,000.00	5,094,430.00
0	ДҮН	7	42,412,178.16	138,488,856.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		42,412,178.16	138,488,856.70
51	Засгийн газрын оруулсан капитал		1,204,052,310.16	1,204,052,310.16
510301	Өмнөх үеийн үр дүн		1,441,479,387.12	1,441,479,387.12
510302	Тайлангийн үеийн үр дүн		00.00	7,814,748,372.42
5104	Дахин үнэлгээний зөрүү		1,064,731,180.80	1,064,731,180.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		3,710,262,878.08	11,525,011,250.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		3,752,675,056.24	11,663,500,107.20

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	/төгрөгөөр/	
			Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		00.00	00.00
13030101	Урсгал		1,205,346,900.00	2,226,578,300.00
130301	Улсын төсвөөс		1,673,615,982.00	2,280,298,384.00
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого		468,269,082.00	53,720,084.00
130301140	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		75,740,218.00	5,358,084.00
130301140	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		392,528,864.00	48,362,000.00
	Бараа, үйлчилгээний орлого		47,998,123.04	579,312,686.00
140201	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		47,998,123.04	579,312,686.00
14020101	Үндсэн үйл ажиллагааны орлого		17,008,000.00	118,280,330.00
14020102	Үндсэн бус үйл ажиллагааны орлого		15,898,530.00	24,759,500.00
14020105	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		15,091,593.04	436,272,856.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1	1,721,614,105.04	2,859,611,070.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,342,008,591.34	2,578,927,833.72
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ		1,004,693,244.00	1,646,999,117.36
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		932,651,258.00	1,489,499,558.68
210101	Цалин		932,651,258.00	1,489,499,558.68
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл		72,041,986.00	157,499,558.68
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		72,041,986.00	146,839,324.68
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		72,041,986.00	136,017,193.88
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		00.00	4,384,093.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		00.00	5,372,014.80
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		00.00	1,066,023.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		00.00	10,660,234.00
2103	Тогтмол зардал		54,431,131.00	152,446,472.99
210301	Гэрэл цахилгааны зардал		23,912,945.00	56,007,212.27
210302	Түлш, халаалтын зардал		26,421,071.00	59,883,511.00
210303	Цэвэр, бохир усны зардал		4,097,115.00	36,555,749.72
2104	Хангамж, бараа материалын зардал		16,220,303.09	43,073,364.63
210401	Бичиг хэргийн материал		4,231,840.00	12,338,928.60
210402	Тээвэр, шатахууны зардал		1,775,870.00	3,600,000.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр		2,734,621.00	11,165,468.03
210404	Ном, хэвлэлийн зардал		1,000,218.00	00.00
210405	Биеийн тамирын уралдаан тэмцээн		00.00	665,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		6,477,754.09	15,303,968.00
2105	Нормативт зардал		40,090,498.00	97,870,200.00
210501	Эм		454,928.00	1,333,000.00
210502	Хоол		39,635,570.00	96,537,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,256,770.00	13,776,612.20
210601	Багаж хэрэгсэл		00.00	2,295,180.00
210604	Урсгал засвар		14,256,770.00	11,481,432.20
2107	Томилолт, зочны зардал		144,000.00	1,372,000.00
210702	Дотоод томилолтын зардал		144,000.00	1,372,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж		29,041,542.00	76,339,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		27,191,782.00	70,670,000.00

210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		00.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр		00.00	453,330.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		251,360.00	225,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		77,800.00	00.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		1,520,600.00	1,991,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		183,131,103.25	547,050,116.54
210901	Бусад зардал		580,000.00	50,230,634.90
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		36,603,081.10	120,598,869.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /үндсэн санхүүжилт/		00.00	25,246,000.06
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/		00.00	3,809,750.00
22010322	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		145,948,022.15	347,164,861.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		264,211,620.00	263,990,850.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		264,211,620.00	263,990,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		676,000.00	254,104,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		250,871,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,664,420.00	9,763,800.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		00.00	122,550.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2	1,606,220,211.34	2,842,918,683.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		115,393,893.70	16,692,386.28
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		00.00	00.00
140502	Хөрөнгийн орлого		00.00	7,798,055,986.14
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		00.00	7,798,055,986.14
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		00.00	00.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		115,393,893.70	7,814,748,372.42

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
		00.00	00.00	00.00	00.00
	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,204,052,310.16	1,064,731,180.80	405,423,987.76	2,674,207,478.72
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	199,475,673.74	199,475,673.74
		00.00	00.00	00.00	00.00
	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,204,052,310.16	1,064,731,180.80	1,441,479,387.12	3,710,262,878.08
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,204,052,310.16	1,064,731,180.80	1,441,479,387.12	3,710,262,878.08
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,814,748,372.42	7,814,748,372.42
	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,204,052,310.16	1,064,731,180.80	9,256,227,759.54	11,525,011,250.50

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	/төгрөгөөр/	
			Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	Тусламж, санхүүжилтын орлого		1,692,423,538.00	2,280,298,384.00
1303	Улсын төсвөөс		1,224,154,456.00	2,226,578,300.00
13030101	Урсгал		1,205,346,900.00	2,226,578,300.00
13030105	Хөрөнгийн		18,807,556.00	00.00
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого		468,269,082.00	53,720,084.00
1303011401	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		75,740,218.00	5,358,084.00
1303011404	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		392,528,864.00	48,362,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого		26,651,530.00	143,039,830.00
1402	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		26,651,530.00	143,039,830.00
14020101	Үндсэн үйл ажиллагааны орлого		17,143,000.00	118,280,330.00
14020102	Үндсэн бус үйл ажиллагааны орлого		9,508,530.00	24,759,500.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1	1,719,075,068.00	2,423,338,214.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,210,609,139.00	2,103,985,263.94
	Ажиллагчидтай холбогдсон зардал		988,703,428.00	1,537,209,700.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		891,403,428.00	1,385,439,400.00
210101	Цалин		891,403,428.00	1,385,439,400.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл		97,300,000.00	151,770,300.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		97,300,000.00	151,770,300.00
	Бараа үйлчилгээний урсгал зардал		221,905,711.00	566,775,563.94
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал		54,431,131.00	158,378,306.99
210301	Гэрэл цахилгааны зардал		23,912,945.00	61,681,567.27
210302	Түлш, халаалтын зардал		26,421,071.00	60,259,738.00
210303	Цэвэр, бохир усны зардал		4,097,115.00	36,437,001.72
2104	Хангамж, бараа материалын зардал		15,640,479.00	16,390,899.95
210401	Бичиг хэрэг		4,694,227.00	1,488,350.00
210402	Тээвэр, шатахуун		2,525,870.00	3,442,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,734,621.00	7,239,156.95
210404	Ном, хэвлэл		1,250,218.00	00.00
210405	Биеийн тамирын уралдаан тэмцээн		00.00	665,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,435,543.00	3,556,303.00
2105	Нормативт зардал		42,225,870.00	102,512,301.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		00.00	1,503,701.00
210502	Хоол, хүнс		39,635,570.00	96,537,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,590,300.00	4,471,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,710,800.00	14,046,776.00
210601	Багаж техник хэрэгсэл		00.00	1,268,500.00
210604	Урсгал засвар		9,710,800.00	12,778,276.00
2107	Томилолт, зочны зардал		144,000.00	1,922,000.00
210702	Дотоод албан томилолт		144,000.00	1,922,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		43,693,199.00	90,154,950.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		28,128,782.00	85,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		00.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		00.00	453,330.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		251,360.00	225,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		77,800.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		14,683,457.00	851,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлдэх		551,800.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		56,060,232.00	183,370,330.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,999,409.00	61,297,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх		53,060,823.00	122,072,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		283,019,176.00	292,924,050.06
3132	Бусад урсгал шилжүүлэг		283,019,176.00	292,924,050.06
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		676,000.00	254,104,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал		250,871,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,664,420.00	9,763,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /үндсэн санхүүжилт/		00.00	25,246,000.06
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/		00.00	3,809,750.00
213210	ХЧТАТэтгэмж		18,807,556.00	00.00
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	2	1,493,628,315.00	2,396,909,314.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		225,446,753.00	26,428,900.00
	Хөрөнгийн орлого		00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		16,084,025.00	26,428,900.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		16,084,025.00	26,428,900.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		16,084,025.00	26,428,900.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-16,084,025.00	-26,428,900.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		00.00	00.00
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр		00.00	00.00
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр		00.00	00.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		209,362,728.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		209,362,728.00	00.00

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,320,044,100.00	2,344,372,129.94	-24,328,029.94	101.05
20	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,320,044,100.00	2,344,372,129.94	-24,328,029.94	101.05
200	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,320,044,100.00	2,344,372,129.94	-24,328,029.94	101.05
2000	Бараа, үйлчилгээний зардал	2,028,343,000.00	2,080,503,829.94	-52,160,829.94	102.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,379,729,400.00	1,379,729,400.00	00.00	100.00
210101	Үндсэн цалин	1,379,729,400.00	1,379,729,400.00	00.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,770,300.00	151,770,300.00	00.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	96,581,100.00	151,770,300.00	-55,189,200.00	157.14
210202	Тэтгэмжийн даатгал	11,037,800.00	00.00	11,037,800.00	00.00
210203	ҮОМШӨ ний даатгал	13,797,300.00	00.00	13,797,300.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,759,500.00	00.00	2,759,500.00	00.00
210205	Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	27,594,600.00	00.00	27,594,600.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,078,000.00	155,040,222.99	37,777.01	99.98
210301	Гэрэл цахилгаан	55,984,800.00	61,139,105.27	-5,154,305.27	109.21
210302	Түлш, халаалт	74,527,300.00	60,259,738.00	14,267,562.00	80.86
210303	Цэвэр, бохир ус	24,565,900.00	33,641,379.72	-9,075,479.72	136.94
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,390,900.00	16,390,899.95	00.05	100.00
210401	Бичиг хэрэг	4,654,000.00	1,488,350.00	3,165,650.00	31.98
210402	Тээвэр (шатахуун)	2,857,500.00	3,442,090.00	-584,590.00	120.46
210403	Шуудан холбоо	6,300,000.00	7,239,156.95	-939,156.95	114.91
210404	Ном хэвлэл авах	00.00	00.00	00.00	00.00
210405	Хог хаягдал устгах цэвэрлэх	170,000.00	665,000.00	-495,000.00	391.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,409,400.00	3,556,303.00	-1,146,903.00	147.60
2105	Нормативт зардал	102,513,200.00	102,512,301.00	899.00	100.00
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,000,000.00	1,503,701.00	-503,701.00	150.37
210502	Хоол, хүнс	96,537,200.00	96,537,200.00	00.00	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	4,976,000.00	4,471,400.00	504,600.00	89.86
2106	Эд хогшил худалдан авах	14,749,000.00	12,778,276.00	1,970,724.00	86.64
210604	Урсгал засвар	14,749,000.00	12,778,276.00	1,970,724.00	86.64
2107	Томилолт, зочны зардал	1,950,000.00	1,922,000.00	28,000.00	98.56
210702	Дотоод албан томилолт	1,950,000.00	1,922,000.00	28,000.00	98.56
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	83,578,400.00	83,154,950.00	423,450.00	99.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,600,000.00	78,400,000.00	200,000.00	99.75
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,000,000.00	3,000,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	453,400.00	453,330.00	70.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	225,620.00	74,380.00	75.21

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000.00	25,000.00	00.00	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,000,000.00	851,000.00	149,000.00	85.10
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	200,000.00	200,000.00	00.00	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	122,583,800.00	177,205,480.00	-54,621,680.00	144.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	54,621,730.00	-54,621,730.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,583,800.00	122,583,750.00	50.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	00.00	254,104,500.00	-254,104,500.00	00.00
2501	ТАТААС	291,701,100.00	263,868,300.00	27,832,800.00	90.46
27	Бусад урсгал шилжүүлэг	291,701,100.00	263,868,300.00	27,832,800.00	90.46
213205	Төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, дэмжлэг	291,701,100.00	00.00	291,701,100.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	9,763,800.00	-9,763,800.00	00.00
6	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,320,044,100.00	2,369,618,130.00	-49,574,030.00	102.14
1.4E+07	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,000,000.00	118,280,330.00	-67,280,330.00	231.92
1.4E+07	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,000,000.00	24,759,500.00	-9,759,500.00	165.06
1.3E+07	Төсвөөс санхүүжих	2,254,044,100.00	2,226,578,300.00	27,465,800.00	98.78
90	АЖИЛЛАГСАД БҮГД	140.00	136.00	04.00	97.14
9001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
9002	Гүйцэтгэх ажилтан	111.00	115.00	-04.00	103.60
9003	Үйлчлэх ажилтан	28.00	20.00	08.00	71.43
95	СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	1,682.00	1,628.00	54.00	96.79

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		49,910,334.00
20	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		49,910,334.00
200	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		49,910,334.00
2000	Бараа, үйлчилгээний зардал		49,910,334.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,710,000.00
210101	Үндсэн цалин		5,710,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,338,084.00
210301	Гэрэл цахилгаан		542,462.00
210303	Цэвэр, бохир ус		2,795,622.00
2106	Эд хогшил худалдан авах		24,950,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,950,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		7,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,000,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал		8,912,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,912,250.00
6	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		53,720,084.00
1.3E+09	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,358,084.00
1.3E+09	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		48,362,000.00
9	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
10	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00
8	БАЙГУУЛЛАГЫН ТОО		00.00
90	АЖИЛЛАГСАД БҮГД		136.00
9001	Удирдах ажилтан		01.00
9002	Гүйцэтгэх ажилтан		115.00
9003	Үйлчлэх ажилтан		20.00
95	СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/		1,628.00
9501	Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад		00.00